# ОРХОН АЙМГИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 09-ны өдөр  Дугаар А/91  Эрдэнэт

Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын
үед хэрэглэх хамгаалах хувцас хэрэгсэл,
түргэвчилсэн оношлуурын хуваарь батлах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дах заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.10 дах заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08-р сарын 13 өдрийн А/520 "Хөрөнгө хуваарилах тухай" тоот тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлын бэлэн байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, хүндрэл багатай даван туулах ажлын хүрээнд сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай хамгаалах хувцас, хэрэгслийн хуваарийг нэгдүгээр, Эрүүл мэндийн газрын нөөцөөс оношилгоонд хэрэглэх түргэвчилсэн оношлуурын хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Коронавируст халдвар /ковид-19/ цар тахалын үед хэрэглэх хамгаалах хувцас хэрэгсэл, түргэвчилсэн оношлуурын чанар, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Эмийн бодлогын хэрэгжилт, чанар, аюулгүй байдал зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн /О.Анхбаяр/-т, Эрүүл мэндийн байгууллагуудад олгох, анхан шатны баримт бичгийн бүртгэлийг бүрдүүлэхийг Эрүүл мэндийн газрын нярав /Б.Алтанзагас/-д тус тус үүрэг болгосугай.

3. Хуваарийн дагуу олгосон хамгаалах хувцас хэрэгсэл, түргэвчилсэн оношлуур, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ, хангалтын багийн дарга /Б.Уртнасан/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Д.СҮХЭЭ

My doc. EMG-iin dargiin tushaal

Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 09 сарын
09 өдрийн А/91 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/ ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ХАМГААЛАХ ХУВЦАС ХЭРЭГСЛИЙН ХУВААРЬ

| № | Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн нэр | Тандалтын тоо /8.14-8.31 хооронд/ | Тандалтын хувь | Хамгаалах хувцас, хэрэгслийн нэр | | | | | | | | | Бүгд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Нэг удаагийн хамгаалах өмсгөл /хайрцагт-30ш/ | | | Нэг удаагийн амны хаалт /хайрцагт-1600ш/ | | | N-95 амны хаалт /хайрцагт-500ш/ | | | |
| | | | | Тоо хэмжээ | Нэгж үнэ | Нийт үнэ | Тоо хэмжээ | Нэгж үнэ | Нийт үнэ | Тоо хэмжээ | Нэгж үнэ | Нийт үнэ | |
| 1 | ЭМГ | - | - | 90 | 19,459 | 1,751,310 | 3,200 | 171 | 547,200 | 500 | 1,310.54 | 655,270 | 2,953,780 |
| 2 | Анхны-Оч ӨЭМТ | 400 | 16.42% | 150 | 19,459 | 2,918,850 | 2,100 | 171 | 359,100 | 410 | 1,310.54 | 537,321.4 | 3,815,271 |
| 3 | Мэндцэцэн ӨЭМТ | 346 | 14.2% | 120 | 19,459 | 2,335,080 | 1,800 | 171 | 307,800 | 350 | 1,310.54 | 458,689 | 3,101,569 |
| 4 | Нийцэл ӨЭМТ | 235 | 9.65% | 80 | 19,459 | 1,556,720 | 1,250 | 171 | 213,750 | 240 | 1,310.54 | 314,529.6 | 2,085,000 |
| 5 | Учралтбаяр ӨЭМТ | 201 | 8.25% | 60 | 19,459 | 1,167,540 | 1,050 | 171 | 179,550 | 200 | 1,310.54 | 262,108 | 1,609,198 |
| 6 | Үйлсбадрах ӨЭМТ | 327 | 13.42% | 100 | 19,459 | 1,945,900 | 1,700 | 171 | 290,700 | 340 | 1,310.54 | 445,583.6 | 2,682,184 |
| 7 | Мөнхийн гэгээ ӨЭМТ | 218 | 8.95% | 60 | 19,459 | 1,167,540 | 1,200 | 171 | 205,200 | 230 | 1,310.54 | 301,424.2 | 1,674,164 |
| 8 | Энхжих мандариваа ӨЭМТ | 262 | 10.76% | 90 | 19,459 | 1,751,310 | 1,350 | 171 | 230,850 | 270 | 1,310.54 | 353,845.8 | 2,336,006 |
| 9 | Мөнхсүндрэл ӨЭМТ | 158 | 6.49% | 60 | 19,459 | 1,167,540 | 850 | 171 | 145,350 | 160 | 1,310.54 | 209,686.4 | 1,522,576 |
| 10 | Жаргалант СЭМТ | 289 | 11.86% | 90 | 19,459 | 1,751,310 | 1,500 | 171 | 256,500 | 300 | 1,310.54 | 393,162 | 2,400,972 |
| | Нийт | | | 900 | | 17,513,100 | 16,000 | | 2,736,000 | 3,000 | | 3,931,620 | 24,180,720 |

Хуваарь гаргасан: ЭМГ-ын ЭБХЧАБЗХХМэргэжилтэн О Анхбаяр
Хянасан: ССНЕБХМэргэжилтэн Н.Чулуун-Эрдэнэ

Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны .09. сарын .04. .өдрийн A/91 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН НӨӨЦӨӨС ОЛГОХ ТҮРГЭВЧИЛСЭН ОНОШЛУУРЫН ХУВААРЬ

| № | СӨЭМТ-үүдийн нэрс | Тоо хэмжээ /ш/ | Нэгж үнэ /төг/ | Нийт /төг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Анхны-Оч ӨЭМТ | 100 | 6,907 | 690,700 |
| 2 | Мэндцэцэн ӨЭМТ | 100 | 6,907 | 690,700 |
| 3 | Нийцэл ӨЭМТ | 100 | 6,907 | 690,700 |
| 4 | Учралтбаяр ӨЭМТ | 100 | 6,907 | 690,700 |
| 5 | Үйлсбадрах ӨЭМТ | 100 | 6,907 | 690,700 |
| 6 | Мөнхийн гэгээ ӨЭМТ | 100 | 6,907 | 690,700 |
| 7 | Энхжих мандариваа ӨЭМТ | 100 | 6,907 | 690,700 |
| 8 | Мөнхсүндрэл ӨЭМТ | 100 | 6,907 | 690,700 |
| 9 | Жаргалант СЭМТ | 100 | 6,907 | 690,700 |
| Нийт | | 900 | | 6,216,300 |

Хуваарь гаргасан: ЭМГ-ын ЭБХЧАБЗХХМэргэжилтэн О.Анхбаяр

Хянасан: ССНББХМэргэжилтэн Н.Чулуун-Эрдэнэ